



ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Х.ЗОЛЖАРГАЛ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.05.21 № 02/48 ЧАТ-ТА/2014/01-ТА

Зөрчлийг арилгуулах тухай

Үндэсний аудитын газрын 2014 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын багцад улсын төсвийн хөрөнгөөр 2013 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүнд аудит хийх явцад дараах зөрчил илэрлээ.

Аудитаар нийт 174.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь шинээр гаргах зарим худгийг гэрээнд заасан хугацаанд ашиглалтанд оруулаагүй, хийгээгүй ажлыг хийснээр хуурамч гүйцэтгэл гарган санхүүжилт авсантай холбоотой байна.


Энэ нь Иргэний хуулийн 350.1.1-д “Гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэнэ”, Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын журам”-ын 4.4-т “Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийг үнэн зөв гаргах, төсвийн хөрөнгийн зарцуулалт, барилгын чанарт тавих хяналтыг Төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцна” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-д “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх” гэж заасныг үндэслэн ШААРДАХ нь:

3. Гүйцэтгэл дутуу ажилд хяналт тавин, 2014 оны 3 дугаар улиралд багтаан ашиглалтанд оруулах, хийгээгүй ажлыг хийснээр хуурамч гүйцэтгэл гаргасан албан тушаалтнуудад арга хэмжээ авах, цаашид дээрх зөрчлийг гаргахгүй байхад анхаарч ажиллах
4. Зөрчлийг арилгуулах талаар авсан арга хэмжээний тухай хариуг 2014 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

АЛБАН ШААРДЛАГА БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Д.ГАНДОЛГОР
Э.УЯНГА

Хугацаандаа ашиглалтад ороогүй, чанаргүй хийгдсэн засварын
ажлын жагсаалт

(сая төгрөгөөр)

| <i>Төсөл арга хэмжээний нэр</i> | <i>Төсөвт өртөг</i> | <i>Зөрчил</i> |
|--|---------------------|---|
| Завхан аймгийн сумдад "Тэсийн бүрд" ХХК инженерийн хийцтэй 8 худаг гаргах | 160.0 | 8 худгийг гаргаагүй боловч хийж гүйцэтгэснээр хуурамч баримт материал бүрдүүлэн санхүүжилт авсан. |
| Архангай аймгийн сумдад "Топ дриллинг" ХХК инженерийн хийцтэй 4 худаг гаргах | 14.6 | 1 худгийг ашиглалтанд өгөөгүй |
| Дүн | 174.6 | |